



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 08 өдөр

Дугаар A/223

Хэрлэн сум

Ажлын уялдаа холбоог сайжруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а" дахь заалт, Засгийн газрын 2016 оны "Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай" 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга нар харьяалах аймгийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагаатай сар тутамд 1 удаа танилцаж, харилцан мэдээлэл солилцон ажлын уялдаа холбоогоо сайжруулж ажилласугай.

2. Аймгийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагаатай сар тутамд танилцах хуваарийг батлан гаргаж хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

011048